



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 160

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, "Ажлын хэсэг байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/725 дугаар захирамжийн 4 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого зохион байгуулах шатахууны зардалд 3,639,432 (гурван сая зургаан зуун гучин есөн мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 3,639,432 (гурван сая зургаан зуун гучин есөн мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН